57 230

# МОНГОЛ УЛСЫН
# БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
# САЙДЫН ТУШААЛ

2013 оны 12 сарын 16 өдөр Дугаар А/456 Улаанбаатар хот

Тушаалд нэмэлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.7 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 19 дугаар тогтоолоор батлагдсан "Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын зээл олгох журам", Хууль зүйн сайдын "Суралцуулах тухай" 2013 оны А/173 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Боловсрол, шинжлэх ухааны сайдын "Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр гадаадад суралцуулах тухай" 2013 оны А/449 дүгээр тушаалын 1 дэх заалтад "Алтангэрэл овогтой Бат-Амгаланг ОХУ-ын Дотоод хэргийн яамны харъяа Удирдлагын академийн магистрантурт" гэж нэмсүгэй.

2.Суралцагчтай гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэлийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Б.Мөнхцэцэг/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Дээд боловсролын хэлтэс /П.Эрхэмбулган/-т тус тус даалгасугай.

Л.ГАНТӨМӨР